



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/145

Улаанбаатар хот

Хүүхдийн тоглоомын талбайд хяналт шалгалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.4, 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 07, 2025 оны “Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээ батлах тухай 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох нөхцөл боломжийг хангах зорилгоор дүүргийн 1-24 дүгээр хороодын нутаг дэвсгэр дэх хүүхдийн тоглоомын талбай, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын орчны аюулгүй байдалд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Н.Бямбагэрэл)-т үүрэг болгосугай.

3. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ